

МОНГОЛЫН УГСААТНЫ ТУХАЙ ӨГҮҮЛСЭН НЭГЭН СЭДЭВТ АЖЛЫН ТУХАЙ ШҮҮМЖ

*М.БАЯНТӨР, Доктор, профессор. МУИС-ийн ГГФ-ийн
Газарзүй-Аялал жуулчлалын тэнхимийн багш*

Судлаач энэ ажлаараа Монголын Хүн Амын Сэтгүүлийн 6 дахь дугаарт нийтлүүлсэн дэд доктор Ц.Цэрэндаш, О.Сүхбаатар нарын "Угсаатнуудын байршил, шилжих хөдөлгөөний үндсэн төрх" сэдэвт материалд өгөх өөрийн санал бодлыг тусган шүүмж бичсэн байна. Шүүмжлэгч нь тухайн өгүүллээс "Сартуул" ястныг ялган авч, түүний хүн амын тоо, байршил, шилжилтийг 2000 оны хүн амын тооллогын материалтай зэрэгцүүлэн үзсэн бөгөөд ихээхэн зөрүүтэй байсанд шүүмжлэлтэй ханджээ. Түүнчлэн "Сартуул"-ын гарал үүслийн талаар түүхэн асуудлыг хөндөж, тэдний өвөг дээдсийг Чингис хаан болон түүний жанжнууд Дундад Азиас олзлон тууж ирсэн гэх Оросын зарим эрдэмтдийн нотолгоог няцааж, "доромжлол" гэж үзсэн байлаа. Эцэст нь Цэвээн Жамсранов, Дорж Банзаров, Х.Нямбуу зэрэг эрдэмтэн мэргэдийн үзэл бодол дээр тулгуурлан "Сартуул" бол ястан биш хуучин Засагт хан аймгийн Цэцэн Сартуул хошууны Халхчуудын нэг хэсэг гэж үзжээ. Харин "Илжгэн Сартуул"-ын тухай энд яригдаагүй болно. Уншигч та шүүмжлэгчийн үзэл бодолтой танилцана уу.

Монголын хүн амын угсаатны гарал, үүсэл, байршил, суурьшлын талаар миний мэдэхээр Орос, Монгол хэл дээр хэвлэгдэн нийтийн хүртээл болсон олон бүтээл байдаг. Гэвч цаг үе улиран өнгөрч байдал өөрчлөгдөхийн хирээр олон ургалч үзлийн үүднээс монгол хүнийхээ сэтгэлгээгээр эргэн авч үзэх хэрэгтэй гэж би боддог.

Ингээд би "Монголын Хүн Амын Сэтгүүл"-ийн 2002 оны дугаар 6-д Хүн Судлалын Үндэсний Төвийн эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн Ц.Цэрэндашийн бичиж нийтлүүлсэн "Угсаатны байршил, шилжих хөдөлгөөний үндсэн төрх" сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлтэй холбогдуулж зарим нэг санаагаа хэлэхээр шийдсэн юм.

Өгүүллийн удиртгал хэсэгт "Монгол улсад амьдарч буй хэл, соёл, амьдралын хэв маягаараа өвөрмөц, онцлог ялгаатай олон ястан, үндэстнүүдийн байршил, тархалт, шилжих хөдөлгөөн, тэдгээрийн түүхийн талаар өгүүлэх болно гээд тэдгээр асуудлыг Монгол улсын одоогийн засаг захиргааны нэгж аймгуудаар **нарийвчлан харьцуулж үзсэн судалгааны ажлын дэлгэрэнгүй үр дүн**" гэж тодорхойлсныг үзээд ихэд олзуурхан уншиж танилцлаа [3.х-33]. Өгүүлэлд халхчуудаас аваад сартуул, хотгойд, илжгэн сартуул, ариг урианхай, дарьганга, дөрвөд, баяд, захчин, урианхайчууд, торгууд, дархад, үзэмчин, барга, казах, хотон, туваа-урианхай нарын тухай тус тусад нь авч үзэж тархалт суурьшлыг харуулжээ. Гэвч энэхүү өгүүлэлд дурьдсан тоо баримтууд хэдэн оных болох нь тодорхойгүй, 2000 оны хүн амын тооллогын дүнтэй харьцуулж үзэхэд ихээхэн зөрж байлаа. Би бүх дурьдсан ястануудын талаар биш зарим ястны талаар санаа бодлоо хуваалцъя гэсэн юм. Жишээ болгож "Сартуул" ястныг авч үзлээ.

Нэгдүгээрт: Зохиогч сартуул ястны хүн ам 25000 орчим гэсэн байна. Гэтэл 2000 оны хүн амын тооллогоор ердөө 1540 хүн өөрийгөө "Сартуул" гэж бүртгүүлсэн байсан. Үүнээс үзэхэд тооны хувьд дэндүү их зөрүүтэй байна. Хүн өөрийгөө ямар үндэстэн ястанд хамруулах нь түүний ухамсар мэдрэмжээс

болдог. Түүнээс биш ч и тэр аймгийн тийм сумын хүн, тийм ястан байх ёстой гэж тулгаж болохгүй нь мэдээж хэрэг. Угсаатны бүтэц нь нийгмийн хөгжлийн явцад үргэлж өөрчлөгдөж байдаг үзэгдэл учраас тэр 25000 орчим хүний ихэнх нь халх гэж бүртгүүлсэн байж болно [3.х-35]. Үүнийг ч эрдэмтэн Ц.Цэрэндаш өөрөө зөвшөөрч байгаа юм.

Хоёрдугаарт: Байршлын хувьд зохиогч Завхан аймгийн баруун хойд талын хил нийлсэн 8 суманд, Ховд аймгийн 2 сум (Дөргөн, Чандмань) Увс аймгийн 3 сум (Зүүнхангай, Цагаанхайрхан, Өндөрхангай), Говь-Алтай аймгийн нэг сум (Хөхморьт)-аар сартуул ястан олон цөөн тоогоор оршин сууж байна гэжээ.

Энэ нь ерөнхийдөө хуучин Засагт хан аймгийн Цэцэн Сартуулын хошууг хэлж байгаа хэрэг. Гэтэл одоо байдал ямар байгааг авч үзвээс Завхан аймагт дөнгөн данган 32 хүн өөрийгөө “Сартуул” гэж бүртгүүлжээ. Дээр нэр дурьдсан сумдаас нэг ч Сартуул хүн бүртгэгдээгүй сум олон бий. Бүх Сартуулуудын 70,7 хувь нь буюу 1089 нь Увс аймагт байгаа дүн гарчээ. Гэтэл Ц.Цэрэндаш доктор Сартуулчууд Увс аймгийн Завхан сумын бараг бүх нутагт, бусад сумдад цөөн тоотой бий [3.х-35] гэсэн байх юм. Ингэхлээр тооны хувьд төдийгүй байршлын хувьд их зөрүү гарч байна. Бас энэ 1089 хүн цөм Сартуул уу? Эсвэл тэдгээрийн зарим нь Илжгэн сартуул уу? гэдэг нь тодорхойгүй.

Гуравдугаарт: Зохиогч - Сартуулчуудын 1/3-ээс илүү нь улсын зэрэглэлд багтах том хотууд (чухам ямар хотууд тэр улсын зэрэглэлд багтдагийг би мэдэхгүй юм) болон төвийн бүсэд шилжин суурьшсан байна гэж нотолжээ. 25000 орчим хүний 1/3 гэдэг нь ойролцоогоор 8,4 мянган хүн байна гэж үзэж болох юм. 2000 оны тооллогоор Улаанбаатар хотод 239, Дарханд 29, Эрдэнэтэд 18, Төв аймагт 46, Говьсүмбэрт 1 сартуул оршин сууж байсан байх юм. Гэхдээ эдгээрийн зарим нь энэ нутагт төрсөн байж болно шүү дээ. Эсвэл энэ 800 гаруй хүн нутагтаа байхдаа “Сартуул” гэж бүртгүүлээд өөр бусад сум, аймаг, хотод шилжин ирээд өөр ястны нэрээр бүртгүүлсэн болж байна уу? Дээр өгүүлснээс үзвэл бусад, ястны тоо, байршил, суурьшил, шилжилтийн талаар ч гэсэн эргэж ёстой л **“нарийвчлан харьцуулж судлах”** шаардлагатай байна шүү!

Дөрөвдүгээрт: Доктор Ц.Цэрэндашийн өгүүлэлд **Монгол улсад амьдарч буй олон ястан, үндэстэн** гэсэн үг өгүүлбэр хэд хэд давтагдлаа. Үндэстэн нь өөртөө нийгмийн шинэ элементийг агуулахын зэрэгцээ ястны элементийг нэгэн адил багтаадаг билээ. Тийм учраас Монгол улсад олон ястан байгаа боловч олон үндэстэн байхгүй. Монгол угсааны ястан дундаас бүрэлдэж байгаа **“Монгол”** гэсэн нэг л үндэстэн бий. Энэ бол Монголын ард түмэн олон зуун жилийн турш эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө хамтран тэмцэж, хөгжин дээдэлсний үр дүн юм.

Монгол улсын шинэ үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн хоёрдугаар зүйлд “Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.” [1.х-3] гэж заасан нь үүнийг баталж байгаа хэрэг. Үндэстний бүх шинжүүдийн дотроос нийтлэг нэг хэлэн дээр тулгуурласан соёл, бичиг үсэг, ухамсар бол хамгийн гол үзүүлэлт гэж эрдэмтэд баталдаг.

Түүхэн явцад Монгол улсаас халх аялгуун дээр тулгуурласан Монгол хэл хөгжиж боловсронгуй болсоор байгаа билээ. Аливаа улсын болон нам, олон нийтийн голлох байгууллагын нэр тэр үндэстнийхээ нэртэй давхцан тохирч

байдаг жамтай. Тийм учраас манай улсыг “Монгол улс, Монгол Улсын Их Хурал” гэх мэтээр нэрлэдэг нь зүйн хэрэг. Сүүлийн үед гадаадын ном хэвлэлд ч гэсэн Монгол улсыг “Нэг үндэстэн давамгайлсан олон ястан бүхий улс” гэж бичих болжээ.

Эрдэмтэд, тэгээд ч хүн ам судлаачид энэ талаар хоёрдмол ойлголттой байж болохгүй гэж би хувьдаа боддог.

Эцэст нь Монголын олон ястны дундаас нэгэнт “Сартуул”-ын талаар яриа дэлгэсэн болохоор олон ургалч үзэл дээр тулгуурлан түүний нэрийн гарал үүслийн талаар өөрийн санаа бодлыг арай дэлгэрэнгүй өгүүлье гэсэн юм.

“Сартуул” гэсэн ястан байсан юм уу? Эсвэл түүхийн явцад гарсан эндүүрэл байв уу? Байсан, одоо ч байгаа гэвэл түүний бусдаас ялгагдах хэл аялгуу, соёл, ахуй амьдралын хэв маяг нь аль вэ? Та ер нь Сартуул ардын дуу, бүжиг гэж дуулсан уу? Нутгийнх байж болно.

Монгол угсаатны их хүн Цэвээн Жамсрановын бичиж, 1934 онд Улаанбаатарт хэвлүүлсэн “Дархад, Хөвсгөл нуурын Урианхай, Дөрвөд, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Хошууд, Дарьганга, Алтайн урианхай, Хасаг, Халимаг нарын гарал үүсэл, байдлын товч” гэсэн өгүүлэлд яагаад “Сартуул” гэсэн нэр алга байна вэ? Энэ нэрсийн жагсаалт бидэнд юу хэлээд байна вэ?

Монгол угсаатны зүйн нэрт судлаач, төрийн соёрхолт, эрдэмтэн Х.Нямбуугийн “Монголын угсаатны зүйн удиртгал” номын 1-р хүснэгтэд 1956, 1963, 1969, 1979 оны тооллогоор тэр үеийн БНМАУ-ын хүн амд 75-0,01 хүртлэх хувь эзлэх ястнуудыг жагсаасан боловч сартуул гэсэн нэр бас байдаггүй.

Эрдэмтэн Дорж Банзаров “Сартуул” (Sartaghol) гэдэг нэр томъёо бол Киданаас үүсэлтэй Хар Хятад (XII-XIII зуун)-ын Монгол нэр мөн гэж үзэж байсан эрдэмтэн И.Я. Шмидтэй хийсэн мэтгэлцээндээ “Сартуул гэдэг бол Хорезм болон Дундад Азиас гаралтай бусад ард түмний хувьд хэрэглэж байсан Сарт гэдэгтэй ойролцоо үг юм” гэж үзсэн байдаг.

Монголын Нууц товчоонд чухам энэ утгаар л Сартуул гэдгийг авч хэрэглэжээ. Түүнийг Оросын зарим эрдэмтэд тухайлбал, Х.М. Ральдин шүүрэн авч “Сартуул гэдэг үг нь Чингис хаан болон түүний цэргийн жанжин нар Дундад Азиас боолууд, гар урчууд тэрчлэн лалын худалдаачдыг бөөнөөр нь олзлон авч, Монголд хөөж ирэгсдээс гаралтай гэж үзэх бүрэн үндэстэй юм /это позволяет предполагать что /” гэжээ [4.х-17].

Энэ бол нөгөө л Монголчууд нүүдэлчид учраас соёл боловсрол гэдгийг мэддэггүй, хот суурингаа хүртэл гадны хүнээр бариулж байсан, Чингис бол харгис, хэрцгий этгээд гэдэг доромжлолын нэгээхэн хэсэг мөн. Уугуул нутаг хошуунаас нь өвөг дээдсийг минь хөөж ирсэн их эзэн Чингис хааныг сартуулчууд бид магтах уу? Ад үзэх үү? (Үүнийг бичигч миний өвөг эцгийг Сартуул нутгийн хүн гэж хэлдэг байсан юм).

Ер хаана, ямар ном зохиолд бидний өвөг дээдсийг Дундад Азиас хэддүгээр зууны хэдэн онд Чингисийнхэн туугаад ирсэн тухай бичсэн байгаа юм бэ? Ямар сайндаа “это позволяет предполагать” гэж бичиж байхав .

Эрдэмтэн Х.Нямбуу “Далдан хөндлөн (Гэрсэнз хун тайжийн гуравдугаар хөвгүүн)-гийн өмчлөн авсан Сартуул, Тангад хоёр отогийнхноос “Цэцэн Сартуул” хэмээх нэгэн хошуу үүссэн нь Сартай уулыг тойрон нутаглажээ. Тэрхүү Сарт уул гэдэг нь Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт буй эртнээс тахилаг тайлгатай байсан Сарт толгой хэмээх бяцхан уул болно.” [4.х-73-74] гэснээс биш хаа байгаа Дундад Азийн түрэг угсааны улсуудаас олзлогдон, туугдаж, хөөгдөж ирсэн гэж нотлоогүй юм. Талийгаач Х.Нямбуу өөрийн хэлснийг улам лавшруулан “БНМАУ-ын Халх Сартуул нь (уншигч та энэ нэрийг сайн анхаарч үзээрэй) хуучин Засагт хан аймгийн Сартуул Цэцэн вангийн хошууны (Цэцэн Сарт-уулын хошууд) . . . нутгийн хүмүүс болно” гэжээ. Энэ бүхнээс тунгаан үзвэл “Сартуул” гэдэг нь орон нутгийн уул усны нэр болохоос ястны нэр лавтайяа биш бололтой.

Завханчууд, Хонгорынхон эсвэл Шандынхан, Хасагт-хайрханыхан гэвэл нутаг усны тодорхой объектыг хэлж байгаа болохоос биш ястныг нэрлээгүй. Үнэнийг хэлэхэд Доктор Ц.Цэрэндаш өөрөө “Сартуул, Хотгойд, Илжгэн халх, Ариг урианхай нар өөрсдийгөө Халх гэж бүртгүүлдэг” хэмээн хүлээн зөвшөөрөөд байгаа юм [3.х-35]. Байдал нэгэнт тийм болчихсон байхад “чи бол халх биш сартуул” гэж хүчээр тулгах хэрэг юунд байна вэ?

Дүгнэж үзвээс:

Сартуул гэдэг нь угаас ястныг хэлсэн биш нутаг хошууных /Сартуул/-ыг тодорхойлсон нэр юм.

НОМ ЗҮЙ:

1. Монгол улсын Үндсэн хууль. УБ. 1992
2. 2000 оны хүн ам орон сууцны тооллого. Үндсэн үр дүн. Монголын ястан үндэстэн. МҮСГ.УБ. 2002
3. Цэрэндаш.Ц., Сүхбаатар. О., Угсаатны байршил, шилжих хөдөлгөөний үндсэн төрх. Монголын хүн амын сэтгүүл УБ. 2002. №6 х.33-42
4. Нямбуу. Х., Монголын угсаатны зүйн удиртгал <<Угсаатны бүрэлдэхүүн гарвал зүй>> УБ.1992
5. Банзаров. Д., Собр. Сочинений. М.1955
6. Проблемы этнографии и этнической историй народов Азии. М. 1968
7. Баянтөр. М., Гунгаадаш. Б., Сүхбаатар. О., БНМАУ-ын хүн амын газарзүйн зарим асуудлууд. УБ.1971